



2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ УЛААНБААТАР
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, МЕНЕЖМЕНТ ҮЦК ХХК



УДИРДТГАЛ

Манай компани нь 2019 оноос Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцсэн, нийгэм эдийн засаг, хүрээлэн буй орчны үр ашигтай, өгөөжтэй төслүүдийг санхүүжүүлэхээр байгуулагдсан. Бид “Нийслэлийн Хөгжлийн сан” болон “Нийслэлийн Ногоон сан”-г 2022 оноос шинжлэх ухаан, технологи, инновацын шийдэлтэй гарааны бизнесүүдийг дэмжсэн, экосистем, мэдээлэл технологийг хөгжүүлдэг гарааны бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжүүдэд санхүүжилт босгох боломжийг олгох зорилготой “Нийслэлийн гарааны бизнесийг дэмжих сан”, Гадаадын болон дотоодын хөрөнгийн зах зээлд арилжаалагдаж буй үнэт цаас, таваар, валют, хаалттай болон нээлттэй компанийн хувьцаа, өрийн хэрэгсэлд хөрөнгө оруулж, компанийн ашигт үйл ажиллагааг нэмэгдүүлэх зорилготой “Нийслэлийн Эрсдэлийн удирдлагын сан”-г тус тус үүсгэн байгуулж, хөрөнгийг удирдан ажиллаж байна.

2022 онд компанийн үр ашгийг нэмэгдүүлэх, эрсдэлийг бууруулах, гүйцэтгэл болон үйл явцыг тасралтгүй сайжруулах, өөрчлөлтүүдийг оновчтой удирдах, үйл ажиллагааг Олон Улсын стандартад нийцүүлэх зорилгоор чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэн, баталгаажуулалтын гэрчилгээг авсан. 2023 онд чанарын менежментийн тогтолцооны хэрэгжилтэд магадлан I, 2024 онд магадлан II аудит хийлгэн, аудитын үр дүнгээр компани дэхь менежментийн тогтолцооны баталгаажуулалтын гэрчилгээг үргэлжлүүлэн хадгалж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ийг үйл ажиллагаандаа даган мөрдөж, ажиллаж байгаа бөгөөд 2024 оны хагас, бүтэн жилийн компанийн засаглалын үнэлгээг Санхүүгийн зохицуулах хорооноос хянан баталгаажуулалтыг хийж, 97,2 хувь буюу компанийн засаглалыг хэвийн, эрсдэлгүй хэмээн үнэлсэн.

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны чиг хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 201 дүгээр тогтоолын хавсралтад заасны дагуу 300,000,000,000 /гурван зуун тэрбум/ төгрөгөөр Бөөрөлжүүтийн цахилгаан станцын төслийг санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн ба энэхүү төслийн санхүүжилтийг “Нийслэлийн Хөгжлийн Сан Хувийн ХОС ТЗК” ХХК-иар дамжуулан хийх санхүүгийн схемийг боловсруулан амжилттай ажиллалаа. Мөн хөрөнгө оруулалт, менежментийн компани болон сангуудын зүгээс хийгдэх хөрөнгө оруулалтуудыг бодит баялаг бүтээгч, бизнес эрхлэгчдийг дэмжих бодлого барьж, МҮХАҮТ, Старт-Ап бизнес инкубатор төвүүд, Олон Улсын бизнес эрхлэгчдийн BNI холбоо зэрэг дотоодын зах зээл дахь цөм болсон бизнесийн холбоодтой хамтын ажиллагаа бий болгохоор зорин ажиллаж байна.

Байгууллагын зүгээс өөрийн үндсэн функц, зорилтын хувьд эх үүсвэр татан төвлөрүүлэх, цар хүрээг тэлэх, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх үүднээс гадаадын олон тооны банк, хөрөнгө оруулалт менежментийн компани, санхүүгийн байгууллагуудтай холбогдож, хамтын ажиллагаа бий болгохыг зорьж ажилласан.

“Алсын хараа – 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар

хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрүүдийг судлан, шалгуур хангах төсөлд хөрөнгө оруулалт хийх, түүнчлэн Монгол Улсын хөрөнгийн зах зээл болон биржийн бус зах зээлийн арилжаанд идэвхтэй оролцож, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэн ажилласан жил байлаа.

Гүйцэтгэх захирал Г.Гангамөрөн

НЭГ. КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

Компанийн нэр:	Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК
Үйл ажиллагааны чиглэл:	- Хөрөнгийн ашиглалт, үр өгөөжийг нэмэгдүүлэх; - Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа; - Хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг итгэмжлэн удирдах; - Үнэт цаасыг итгэмжлэн удирдах; - Хувийн тэтгэврийн сангийн хөрөнгийг итгэмжлэн удирдах; - Даатгалын компанийн нөөц хөрөнгийг итгэмжлэн удирдах; - Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ.
Итгэмжлэн удирдаж буй хувийн ХОС :	- Нийслэлийн Хөгжлийн сан - Нийслэлийн Ногоон сан - Нийслэлийн Гарааны бизнесийг дэмжих сан - Нийслэлийн Эрсдэлийн удирдлагын сан
Компанийн удирдлага:	- ТУЗ-ийн дарга Р. Дагва - Гүйцэтгэх захирал Г. Гангамөрөн
Үүсгэн байгуулагдсан огноо:	2019 оны 05 дугаар сарын 07-ны өдөр
Нийт ажилтны тоо:	22
Компанийн хаяг:	Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, Эко интернэйшнл тауэр, 16 давхар, 1604 тоот, Утас: 976 77171414

1.2. КОМПАНИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

“Нийслэлийн өмчит Улаанбаатар Хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК” ХХК нь Нийслэл Улаанбаатар хотын бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын салбарт үйл ажиллагаа явуулах, үр ашгийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, сангийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа явуулах чиг үүрэг бүхий компани юм.

ЭРХЭМ ЗОРИЛГО

“Нийслэлийн тогтвортой хөгжил, хөрөнгө оруулалтын ашигт байдлыг эрхэмлэнэ”

АЛСЫН ХАРАА

“Нийслэлд шинийг санаачлагч, тогтвортой хөгжлийг дэмжигч, салбартаа тэргүүлэгч компани болох”

ҮНЭТ ЗҮЙЛС

- Мэргэжлийн ёс зүй
- Мэргэшсэн хамт олон
- Хамтын ажиллагаа
- Бүтээлч сэтгэлгээ
- Мэдээллийн ил тод байдал

1.3. ИТГЭМЖЛЭН УДИРДАЖ БУЙ САНГУУДЫН ТАНИЛЦУУЛГА, ГҮЙЦЭТГЭЛ

Хувийн хөрөнгө оруулалтын сан нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан дүрэм, журам, заавар холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа удирдлага болгон ашгийн төлөө хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг эрхэлж буй хуулийн этгээдийн эрхтэй, тусгай зориулалтын компани юм.

НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН САН ХУВИЙН ХОС ТЗК ХХК

Сангийн зорилго: Монгол Улсын тогтвортой үзэл баримтлал, Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцсэн, нийгэм эдийн засгийн үр ашигтай, дунд болон урт хугацааны төсөл, төслийн хэрэгжүүлэлтэд мэргэжлийн хөрөнгө оруулагчидтай хамтран хөрөнгө оруулах, хэрэгжүүлэх, хөрөнгийг өсгөн нэмэгдүүлэхэд оршино.

Үүсгэн байгуулагдсан хугацаа	2020.02.12
Дүрмийн сан	310,000,000,000₮
Нэгж эрхийн төрөл	Хаалттай
Нэгж эрхийн нэрлэсэн үнэ	1,000,000₮
Нийт актив	302,000,000,000₮
Хөрөнгө оруулалтын хэлбэр	ХОС-ийн хуулиар зөвшөөрөгдсөн 12 хэрэгсэл
Санал болгох хүрээ	Мэргэжлийн хөрөнгө оруулагчид
Хөрөнгө оруулалтын чиглэл	- Аж үйлдвэр - Авто тээвэр - Дэд бүтэц, Эрчим хүч - Барилга - Бусад

2024 оны гүйцэтгэл:

Хүснэгт №01. 2024 оны 12 сарын 31-ний өдрөөрх хөрөнгийн хуваарилалт

Төрөл	Нэр	Өртөг /төгрөгөөр/	Зах зээлийн үнэ	Хувийн жин
Мөнгөний зах зээл	Харилцах	197,672,870	197,672,870	0.07%
	Хадгаламж Голомт банк	350,000,000	350,062,328	0.12%
	Хадгаламж Худалдаа Хөгжлийн Банк	350,000,000	350,119,863	0.12%
Бонд	Бөөрөлжүүт цахилгаан станц бонд	300,000,000,000	301,068,164,383	99.08%
	Мик бонд 1.3	300,000,000	311,243,835	0.10%
	Шунхлай Бонд	900,000,000	912,156,164	0.30%
	Жем Тосон Энержи Бонд 1.8	500,000,000	503,945,205	0.17%
	Покет бонд 1.2	200,000,000	207,397,260	0.07%
Нийт		302,797,672,870	303,900,761,911.	100.00%

Нийслэлийн хөгжлийн сангийн нэгж эрхийн үнэ 2024 оны жилийн эцсийн байдлаар



1,002,188 төгрөг буюу өмнөх жилээс буурсан үзүүлэлттэй байгаа нь хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн зардал өндөртэй холбоотой бөгөөд цаашид зардлыг багасгаж, нэгж эрхийн үнийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллахаар төлөвлөж байна.

НИЙСЛЭЛИЙН НОГООН САН ХУВИЙН ХОС ТЗК ХХК

Сангийн зорилго: Нийслэл хотын орчны бохирдол болон хүлэмжийн хийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон эдийн засгийг дэмжих санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлж, байгаль хамгаалал, цэвэр технологийг дэмжих төслийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд оршино.

Үүсгэн байгуулагдсан хугацаа	2020.02.12
Дүрмийн сан	100,000,000,000₮
Нэгж эрхийн төрөл	Хаалттай
Нэгж эрхийн нэрлэсэн үнэ	1,000,000₮
Нийт актив	100,000,000₮
Хөрөнгө оруулалтын хэлбэр	ХОС-ийн хуулиар зөвшөөрөгдсөн 11 хэрэгсэл
Санал болгох хүрээ	Мэргэжлийн хөрөнгө оруулагчид
Хөрөнгө оруулалтын чиглэл	- Хүлэмжийн хийг бууруулах - Ногоон эдийн засгийг дэмжих - Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах - Орчны бохирдол бууруулах - Ногоон ажлын байр бий болгох - Экосистемийг бий болгох

2024 оны гүйцэтгэл:

Хүснэгт №02. 2024 оны 12 сарын 31-ний өдрөөрх хөрөнгийн хуваарилалт

Төрөл	Нэр	Өртөг /₮/	Зах зээлийн үнэ /₮/	Хувийн жин
Мөнгөний зах зээл	Харилцах	4,556.33	4,556.33	0.00%
	Хадгаламж	118,000,000.00	118,040,410.96	100.00%
Нийт		118,004,556.33	118,044,967.29	100.00%



2024 оны жилийн эцсийн байдлаар Нийслэлийн Ногоон сангийн нэгж эрхийн үнэлгээ 1,166,338 төгрөг болж өмнөх оны мөн үеэс 7.9 хувийн өсөлттэй ажилласан байна. Уг дүн нь үндэсний валютад оруулсан хөрөнгө оруулалтын өгөөжөөс бий болж байна.

НИЙСЛЭЛИЙН ГАРААНЫ БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ САН ХУВИЙН ХОС ТЗК ХХК

Сангийн зорилго: Монгол Улсад үйл ажиллагаа явуулж эхлэх гэж буй болон үйл ажиллагаа хараахан тогтворжоогүй байгаа гарааны бизнесүүдэд хөрөнгө оруулж, цаашлаад Нийслэлийн тогтвортой хөгжлийг дэмжиж, үр өгөөжтэй ажиллах.

Үүсгэн байгуулагдсан хугацаа	2022.06.22
Дүрмийн сан	20,000,000,000₮
Нэгж эрхийн төрөл	Хаалттай
Нэгж эрхийн нэрлэсэн үнэ	1,000,000₮
Нийт актив	500,000,000₮
Хөрөнгө оруулалтын хэлбэр	ХОС-ийн хуулиар зөвшөөрөгдсөн 12 хэрэгсэл
Санал болгох хүрээ	Мэргэжлийн хөрөнгө оруулагчид
Хөрөнгө оруулалтын чиглэл	- Эрүүл мэнд - Мэдээлэл технологи - Боловсрол - Тээвэр логистик - Инноваци - Бусад

2024 оны гүйцэтгэл:

Хүснэгт №03. 2024 оны 12 сарын 31-ний өдрөөрх хөрөнгийн хуваарилалт

Төрөл	Нэр	Өртөг /₮/	Зах зээлийн үнэ /₮/	Хувийн жин
Мөнгөний зах зээл	Харилцах	30,355,825	30,355,825	4.87%
	Хадгаламж - Голомт банк	33,521,479	33,521,479	5.37%
	Хадгаламж - ХХБанк	210,000,000	210,071,917	33.66%
Бонд	Мик бонд 1.3	100,000,000	104,389,041	16.03%
	Бичил Глобус бонд 18	150,000,000	158,198,630	24.04%
	Покет бонд 1.2	100,000,000	103,698,630	16.03%
Нийт		623,877,305	640,235,524	100.00%



эцсийн байдлаар сангийн нэгж эрхийн үнэлгээ 1,332,356 төгрөг буюу өмнө жилийн мөн үеэс 22%-ийн өсөлттэй ажилласан нь сангийн хөрөнгийг үр өгөөжтэй ашиглан зарцуулсантай холбоотой.

Цаашид сангийн бодлогын баримт бичиг, дүрэмд

нийцүүлэн сангийн хөрөнгийг оновчтой удирдаж, нэгж эрхийн үнэлгээг улам өсгөх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

НИЙСЛЭЛИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН САН ХУВИЙН ХОС ТЗК ХХК

Сангийн зорилго: Гадаадын болон дотоодын хөрөнгийн зах зээлд арилжаалагдаж буй үнэт цаас, таваар, валют, хаалттай болон нээлттэй компанийн хувьцаа, өрийн хэрэгсэлд хөрөнгө оруулж компанийн ашигт үйл ажиллагааг нэмэгдүүлэх.

Үүсгэн байгуулагдсан хугацаа	2022.06.22
Дүрмийн сан	10,000,000,000₮
Нэгж эрхийн төрөл	Хаалттай
Нэгж эрхийн нэрлэсэн үнэ	1,000,000₮
Нийт актив	500,000,000₮
Хөрөнгө оруулалтын хэлбэр	ХОС-ийн хуулиар зөвшөөрөгдсөн 12 хэрэгсэл
Санал болгох хүрээ	Мэргэжлийн хөрөнгө оруулагчид
Хөрөнгө оруулалтын чиглэл	- Уул уурхай, олборлолт, - ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, - Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ, - Боловсрол, - Боловсруулах үйлдвэр

Хүснэгт №04. 2024 оны 12 сарын 31-ний өдрөөрх хөрөнгийн хуваарилалт				
Төрөл	Нэр	Өртөг /₮/	Зах зээлийн үнэ /₮/	Хувийн жин
Мөнгөний зах зээл	Харилцах	49,495,755.03	49,495,755.03	7.51%
	Хадгаламж - ХХБанк	260,000,000.00	260,089,041.10	39.42%
Хөрөнгийн зах зээл	Бичил Глобус бонд 18	150,000,000.00	158,198,630.14	22.74%
	Мик бонд 1.3	100,000,000.00	104,389,041.10	15.16%
	Ленд бонд	100,000,000.00	100,690,410.96	15.16%
Нийт		659,495,755.03	672,862,878.33	100.00%

НЭУС-ийн нэгж эрхийн үнэлгээ

Тайлбар	Нэгж эрхийн үнэ (MNT)	Нэгж эрхийн өсөлтийн хувь (%)
2023.II	1,090,302	105%
2023.IV	1,171,713	115%
2024.II	1,281,422	125%
2024.IV	1,334,774	135%

хэрэгслийн багцыг
сангийн дүрэм, бодлогын
баримт бичигт нийцүүлэн
оновчтой удирдаж, нэгж
эрхийн үнэлгээг улам
өсгөх төлөвлөгөөтэй
ажиллаж байна.

ХОЁР. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

2.1. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

Компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал юм. Хувьцаа эзэмшигчдийн хурлын эрх, үүргийг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал хэрэгжүүлэн ажиллаж байна.

2.2. ТУЗ-ИЙН МЭДЭЭЛЭЛ

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна.

Манай компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүн 2024 онд шинэчлэгдэн, 2024 оны 118 дугаар НИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 24/17 дугаар тогтоолоор Л.Хосбаяр, Б.Дөлгөөн, Ч.Төгсдэлгэр, Б.Энхжин, Д.Гантулга, Г.Өлзийсайхан нарыг тус тус ТУЗ-ийн ердийн гишүүнээр томилж, өмнөх ТУЗ-ийн гишүүдийг чөлөөлсөн. НИТХ-ын 2025 оны 25/18 дугаар тогтоолоор ердийн гишүүн Ч.Төгсдэлгэрийг чөлөөлж, Г.Батбаярыг томилсон. Тус компани 2024 оны 12 сарын 19-ны өдөр ТУЗ-ийн хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалтыг хийж НИТХ-д хэлэлцүүлэн 2025 оны 25/33 тогтоолоор хараат бус гишүүнээр Б.Баярмаа, Т.Баасанжав, Д.Хүрэлбаатар нарыг томилж ТУЗ бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллах боломж бүрдсэн.

ТУЗ-ИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Тайлант хугацаанд ТУЗ-ийн 5 удаагийн ээлжит хурлыг танхим болон цахимаар зохион байгуулж, нийт 23 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Мөн Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг ханган ажилласан бөгөөд “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга хийж гүйцэтгэн, үр дүнг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга хянаж баталсан.

Тус үнэлгээ нь засаглалын 9 зарчмын хүрээнд нийт 36 асуулгын дагуу компанийн засаглалд холбогдох үйл ажиллагааг Санхүүгийн зохицуулах хороонд 2024 оны 06 дугаар сар,

2024 оны 12 дугаар сард тус тус хийж тайлагнан ажилласан. 2024 оны жилийн тайланг Санхүүгийн зохицуулах хорооноос хянан баталгаажуулалтыг хийн, компанийн засаглалыг 97,2%-иар үнэлсэн.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛААС 2024 ОНД ГАРСАН ТОГТООЛ,
ШИЙДВЭРҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ

№	Тогтоолын дугаар	Огноо	Хурлаас гарсан шийдвэр	Шийдвэрийн хэрэгжилт	Хувь
1	01/01	2023.04.28	Компанийн 2023 оны оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд дүгнэлт гаргах тухай	Хангалттай гэж дүгнэгдсэн	100%
2	01/02		Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөг батлах тухай	Бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан.	100%
3	01/03		Компанийн 2024 оны үйл ажиллагааны төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай	Батлагдсан төсөв төлөвлөгөөний дагуу ажилласан.	100%
4	01/04		Гүйцэтгэх захирлын хөдөлмөрийн гэрээг сунгах тухай	Гүйцэтгэх захиралтай байгуулсан хөдөлмөрийн гэрээг бүрэн хангалттай гэж дүгнэн, Хөдөлмөрийн гэрээг байгуулан ажилласан.	100%
5	01/05		Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК -ийн бүтэц, орон тоо, цалин хөлсний дээд хязгаар, шатлалыг шинэчлэн батлах тухай	Батлагдсан бүтэц орон тоо, цалин хөлсөөр ажилласан.	100%
6	01/06		Ажилтнуудад урамшуулал олгох тухай	Нийт ажилтнуудад урамшуулал олгосон.	100%
7	01/07		Гүйцэтгэх захиралд урамшуулал олгох тухай	3 сарын цалинтай тэмцэх хэмжээний урамшууллыг олгосон.	100%
8	01/08		Төлөөлөн удирдах зөвлөлийн хороодын дарга, бүрэлдэхүүнийг томилох тухай	Компанийн ТУЗ-ийн Аудитын, Нэр дэвшүүлэх, цалин	100%

				урамшууллын хороодыг байгуулсан.	
9	01/09		Компанийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөрийн шинэчилсэн найруулгыг батлах тухай	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөрийг баталсан.	100%
10	01/10		Эд хөрөнгө актлах тухай	Компанийн ашиглах хугацаа дууссан, акт тогтоон устгах эд хөрөнгийг устгах тогтоол баталсан	100%
11	01/11		Зөвшөөрөл олгох тухай	Банканд 3,000,000,000 төгрөг хүртэлх хэмжээгээр хадгалуулах эрхийг гүйцэтгэх захиралд олгосон.	100%
12	01/12		Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох тухай	Б.Насанжаргалын төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар томилсон.	100%
13	02/01	2024.06.25	Бөөрөлжүүтийн цахилгаан станцын төсөлд Нийслэлийн хөгжлийн сан хувийн ХОС ТЗК ХХК-иас хөрөнгө оруулах тухай	Бөөрөлжүүтийн цахилгаан станцад 300,000,000,000 төгрөгийн хөрөнгө оруулсан.	100%
14	03/01	2024.07.23	Гүйцэтгэх захирлыг чөлөөлөх тухай	Гүйцэтгэх захирал Л.Тэмүүжинтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээг цуцалсан.	100%
15	03/02		Гүйцэтгэх захирал томилох тухай	Ө.Мөнхдавааг гүйцэтгэх захирлаар томилсон.	100%
16	04/01	2024.09.13	Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг томилох тухай	Р.Дагвыг ТУЗ-ийн даргаар томилсон.	100%
17	04/02		Гүйцэтгэх захирлыг чөлөөлөх тухай	Ө.Мөнхдавааг гүйцэтгэх захирлын ажил үүргээс чөлөөлсөн	100%
18	04/03		Гүйцэтгэх захирлыг томилох тухай	Г.Гангамөрөн гүйцэтгэх захирлаар томилсон.	100%

19	05/01	2024.10.23	Төлөөлөн удирдах зөвлөлийн хороодын дарга, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай	Компанийн ТУЗ-ийн Аудитын, Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороодыг байгуулсан.	100%
20	05/02		Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох тухай	И.Төгс-Оюуныг төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар томилсон.	100%
21	05/03		Компанийн бүтэц, орон тоо, цалин, хөлсний шатлалын болон албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай	Компанийн бүтэц, орон тоо, цалин хөлсний шатлалын болон албан тушаалын жагсаалтыг баталсан.	100%
22	05/04		Компанийн 2024 оны төсвийн тодотгол, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай.	Батлагдсан төсөв төлөвлөгөөний дагуу ажилласан.	100%
23	05/05		Эрх олгох тухай.	Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.	100%

АУДИТЫН ХОРОО

Тайлант хугацаанд компанийн дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ТУЗ-ийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд компанийн Дотоод хяналт, эрсдэлийн албыг удирдлагаар хангаж, үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө, хяналт шалгалтын ажлын удирдамжийг батлан, үүрэг даалгавар, чиглэл өгч ажилласан.

НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО

Тайлант хугацаанд ТУЗ-ийн хараат болон ердийн гишүүнийг сонгон шалгаруулах ажил үүргийг хариуцан ажиллаж 13 гишүүнийг чөлөөлж, 12 гишүүнийг томилуулан ажилласан.

ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ХОРОО

Тайлант хугацаанд тус хороо хууль, тогтоомжид нийцүүлэн 2024 оны компанийн бүтэц, орон тоо, цалин, хөлсний дээд хязгаар, шатлалыг шинэчлэн батлуулсан.

2.3. КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн (ТУЗ)-ийн 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 05/03 дугаар тогтоолоор

```

graph TD
    A[ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ] --> B[ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ-9]
    B --> C[Нэр дэвшүүлэх хороо-3]
    B --> D[Цалин урамшууллын хороо-3]
    B --> E[Аудитын хороо-3]
    B --> F[ТУЗ-ийн нарийн бичгийн дарга-1]
    B --> G[ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ-1]
    G --> H[ДОТООД ХЯНАЛТ, ЭРСДЭЛИЙН АЛБА-3]
    G --> I[Эрсдэлийн зөвлөл-5]
    G --> J[ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР-1]
    J --> K[ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨСЛИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР-6]
    J --> L[САНГИЙН УДИРДЛАГА, ЭХ ҮҮСВЭРИЙН ГАЗАР-6]
    J --> M[ҮЙЛ АЖИЛЛАГАА, КОМПЛАЙНСЫН ГАЗАР-8]
    
    subgraph K_Box [ ]
        direction TB
        K1[• Ахлах хянан шалгагч - 1]
        K2[• Ахлах хуульч - 1]
        K3[• Эрсдэлийн менежер - 1]
    end
    
    subgraph L_Box [ ]
        direction TB
        L1[▪ Газрын дарга - 1]
        L2[▪ Бизнесийн шинжээч - 2]
        L3[▪ Санхүүгийн шинжээч - 2]
        L4[▪ Маркетинг, дотоод зах зээлийн харилцааны менежер - 1]
    end
    
    subgraph M_Box [ ]
        direction TB
        M1[▪ Газрын дарга - 1]
        M2[▪ Сангийн менежер - 4]
        M3[▪ Байгаль орчин, нийгэм, засаглалын менежер - 1]
    end
    
    subgraph N_Box [ ]
        direction TB
        N1[▪ Газрын дарга - 1]
        N2[▪ Нягтлан бодогч - 1]
        N3[▪ Хууль эрх зүйн комплаинсын менежер - 1]
        N4[▪ Захиргаа, хүний нөөцийн менежер - 1]
        N5[▪ Албан хэрэг хөтлөлтийн менежер (нярав) - 1]
        N6[▪ Мэдээллийн аюулгүй байдал, технологи хариуцсан менежер - 1]
        N7[▪ Гүйцэтгэх захирлын ажлын албаны менежер - 1]
        N8[▪ Гадаад харилцааны менежер - 1]
    end

```

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

- ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ-9**
 - Нэр дэвшүүлэх хороо-3
 - Цалин урамшууллын хороо-3
 - Аудитын хороо-3
 - ТУЗ-ийн нарийн бичгийн дарга-1
- ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ-1**
 - ДОТООД ХЯНАЛТ, ЭРСДЭЛИЙН АЛБА-3
 - Ахлах хянан шалгагч - 1
 - Ахлах хуульч - 1
 - Эрсдэлийн менежер - 1
 - Эрсдэлийн зөвлөл-5
 - ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР-1**
 - ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨСЛИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР-6**
 - Газрын дарга - 1
 - Бизнесийн шинжээч - 2
 - Санхүүгийн шинжээч - 2
 - Маркетинг, дотоод зах зээлийн харилцааны менежер - 1
 - САНГИЙН УДИРДЛАГА, ЭХ ҮҮСВЭРИЙН ГАЗАР-6**
 - Газрын дарга - 1
 - Сангийн менежер - 4
 - Байгаль орчин, нийгэм, засаглалын менежер - 1
 - ҮЙЛ АЖИЛЛАГАА, КОМПЛАЙНСЫН ГАЗАР-8**
 - Газрын дарга - 1
 - Нягтлан бодогч - 1
 - Хууль эрх зүйн комплаинсын менежер - 1
 - Захиргаа, хүний нөөцийн менежер - 1
 - Албан хэрэг хөтлөлтийн менежер (нярав) - 1
 - Мэдээллийн аюулгүй байдал, технологи хариуцсан менежер - 1
 - Гүйцэтгэх захирлын ажлын албаны менежер - 1
 - Гадаад харилцааны менежер - 1

НИЙТ 25 ОРОН ТОО

Монгол Улсын үнэт цаасны зах зээлтэй холбоотой болон төрийн өмч, төсөв, санхүү, татвар нийгмийн даатгал, компанийн тухай хуулиуд болон УИХ-ын болон Засгийн газрын тогтоол, шийдвэрүүд, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж бусад бодлогын баримт бичгүүдийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

НӨУБХОМ ҮЦК ХХК-ИЙН МӨРДӨН АЖИЛЛАЖ БУЙ ХУУЛЬ ТОГТООМЖ,

ЭРХ ЗҮЙН АКТУУД

№	ХУУЛЬ, ДҮРЭМ, ЖУРМЫН ЖАГСААЛТ	БАТАЛСАН БАЙГУУЛЛАГА
САЛБАРЫН ХУУЛИУД		
1	Компанийн тухай хууль	УИХ
2	Үнэт цаасны зах зээлийн тухай хууль	УИХ
3	Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль	УИХ
4	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль	УИХ
5	Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль	УИХ
6	Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль	УИХ
7	Төрийн хяналт шалгалтын тухай хууль	УИХ
8	Хөдөлмөрийн тухай хууль	УИХ
9	Зөрчлийн тухай хууль	УИХ
10	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль	УИХ
11	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль	УИХ
12	Авлигын эсрэг хууль	УИХ
13	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль	УИХ
14	Өрийн удирдлагын тухай хууль	УИХ
15	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль	УИХ
16	Татварын багц хууль	УИХ
17	Нийгмийн даатгалын багц хууль	УИХ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ЖУРАМ		
1	Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам	СЗХ
2	Хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгүүлэх тухай журам	СЗХ
3	Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн мэргэжлийн үйл ажиллагааны болон ажилтны ёс зүйн дүрэм	СЗХ
4	Хөрөнгө оруулалтын сангийн нягтлан бодох бүртгэл хөтлөх, үйлчилгээ үзүүлэх мэргэшсэн нягтлан бодогчийг бүртгэх тухай журам	СЗХ
5	Хөрөнгө оруулалтын сангийн санхүүгийн тайлан бэлтгэх, нягтлан бодох бүртгэл хөтлөх, цэвэр хөрөнгийг үнэлэх заавар	Сангийн яам/СЗХ

ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ЖУРАМ


1	Мэргэжлийн шалгаруулалт явуулах, мэргэжилтэнд эрх олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай журам	СЗХ
2	Зохицуулалттай этгээдийн эрсдэлийн сангийн журам	СЗХ
3	Зохицуулалттай этгээдийн мэдээллийн сангийн журам	СЗХ
4	Хувьцааны арилжаанаас авах хураамжийн дээд хязгаарыг шинэчлэн тогтоох тухай	СЗХ
5	Кастодианы тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам	СЗХ
6	Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм батлах тухай	СЗХ
7	Биржийн бус зах зээлийн ерөнхий журам	МҮЦАЭХ

ГУРАВ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

3.1. ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГА

Бид чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, тогтвор суурьшилтай ажиллуулах, чадавхийг сайжруулах бодлогыг баримтлан ажиллаж байна. Түүнчлэн компанийн сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт зарлан, шинэ ажилтны дасан зохицуулах хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Компанийн хүнийн нөөцийн орон тооны хувьд: 2024 оын 10-р сарын 23-ний өдрийн 05/03 дугаар тогтоолоор компанийн бүтцийг 3 газар, 1 алба, 1 зөвлөл нийт 25 албан хаагчтайгаар шинэчлэн баталсан. Тус бүтэц орон тооны дагуу 22 албан хаагч ажиллаж байгаа бөгөөд 2 орон тоонд сонгон шалгаруулалт хийгдэж туршилтын хугацаагаар ажилуулах санал тавьсан, хүлээгдэж байна.



Нийт ажилтнуудын 37% нь эрэгтэй, 63% нь эмэгтэй ажилтнууд байна.

СУРГАЛТ ХӨГЖИЛ

Компанийн боловсон хүчний мэдлэг, боловсролыг тасралтгүй сайжруулах, ажилтны ур чадвар, чадамжийг нэмэгдүүлэх зорилгоор жил бүр сургалт хөгжлийн хөтөлбөр гарган, төсөв батлуулдаг бөгөөд түүний дагуу хэрэгжилтийг ханган ажилладаг. 2024 онд мэргэжлийн байгууллагаас зохион байгуулагддаг 7 төрлийн сургалт, компанийн дотоод 3 сургалт, нийт 10 сургалтыг зохион байгуулсан бөгөөд уг сургалтуудын зардалд 11,2 сая төгрөг зарцуулсан байна. Үүнд:

Төрөл	Зохион байгуулсан	Хамрагдсан			Сургалтын төлбөр
		Сургалтын нэр	Хугацаа	Ажилтны тоо	
Мэргэжлийн байгууллагын сургалт	Компаний засаглалын хөгжлийн төв	Компанийн засаглалын сургалт	2 өдөр	3	1,350,000
	МУЦАЭХ	Үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын мэргэшлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн сургалт	1 өдөр	11	7,920,000
	Хуульчдын холбоо	Хуулийн сургалт	1 өдөр	2	350,000
	Сайн худалдан авалтын зөвлөх	A3 сертификатын сургалт	7 өдөр	3	255,000
	Монсертф аудит	ISO90012015 сургалт	1 өдөр	3	1,003,200

Компанийн дотоод сургалт	АШУҮИС-ын багш нарын тэнхим	Стресс менежмент сургалт	1 удаа	1	300,000
	АТГ	Хууль, эрх зүйн актын нэмэлт, өөрчлөлт, шинэчлэлт	1 өдөр	19	0.00
	ҮАКГ-ын дарга Л.Цолмонтуяа, Ахлах хянан шалгагч Л.Сайзмаа	Гүйцэтгэлийн төлөвлөгөө НЗД-тай байгуулах хариуцлагын гэрээний талаарх сургалт	1 удаа	10	0.00
	ТУЗ-ын хараат бус гишүүн Байлхүү	Засаглалын кодексын сургалт	2 удаа	19	0.00
	Сангийн менежер Х.Оюунжунай	БОНЗ-ын сургалт	3 удаа	10	0.00

3.2. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС

Компанийн засаглалын хэрэгжилтийг ТУЗ хариуцан ажилладаг бөгөөд Хувьцаа эзэмшигч, Төлөөлөн удирдах зөвлөл болон хөндлөнгийн аудитаар дамжуулан компанид зохистой засаглалын бүтэц, зохион байгуулалт бүрэлдсэн эсэхэд хяналт тавин ажиллаж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 145 дугаар тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан “Компанийн засаглалын кодекс” болон “Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын хүрээнд компанийн үйл ажиллагаанд баримтлах хөтөлбөр, бодлого, журмуудыг компанийн ТУЗ-өөс баталсан. Тус баримт бичгүүдийг компанийн www.ubim.mn албан ёсны вэб сайтад байршуулан, мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж байна.

Компанид засаглалын Олон Улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг нэвтрүүлэх замаар хөрөнгө оруулагч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, урт хугацаанд тогтвортой үнэ цэн бүтээхэд дэмжлэг үзүүлэхэд СЗХ-ны баталсан засаглалын кодексийн дараах 9 зарчмуудыг хэрэгжүүлсэн.

№	Зарчим	Зарчмын тайлбар
---	--------	-----------------

1-р зарчим	Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт	Төлөөлөн удирдах зөвлөл нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна.
2-р зарчим	Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ.
3-р зарчим	Тайлагнал, мэдээллийн ил тод байдал	Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана.
4-р зарчим	Аудит, хяналтын тогтолцоо	Төлөөлөн удирдах зөвлөл нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана.
5-р зарчим	Эрсдэлийн удирдлага	Төлөөлөн удирдах зөвлөл нь эрсдэлийн удирдлага болон Компаенсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина.
6-р зарчим	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна.
7-р зарчим	Оролцогч талуудын эрх ашиг	Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ.
8-р зарчим	Компанийн соёл	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно.
9-р зарчим	Хувьцаа эзэмшигчдийн эрх	Компани болон төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана.

Засаглалын кодексийн хэрэгжилтийн тайланг гарган Санхүүгийн зохицуулах хороонд тайлагнасан.

Үнэлгээний бүтэц: “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээ нь нийт 36 асуулгатай.

Үнэлгээний аргачлал: Асуулга тус бүрийн хувьд бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан бол 2, хэсэгчлэн хэрэгжүүлсэн, эсхүл хугацаа бүхий хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилтоо тайлбарласан бол 1, үнэлгээ ирүүлээгүй бол 0 гэсэн оноогоор тус тус үнэлдэг ба хэрэгжилт болон тайлбарыг тус бүрээр нь оруулах байдлаар тайлагнадаг.

Үнэлгээний нэгдсэн дүнд үндэслэн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлсэн. Үүнд:

1. Авбал зохих нийт онооны 90 хувь болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй;
2. 70-89 хувь байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсэж болзошгүй тул зөвлөмж хүргүүлэх;
3. 50-69 хувь байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй тул зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;
4. 49 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай.

СЗХ-НООС 2024 ОНЫ ЖИЛИЙН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙГ
ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН ҮНЭЛГЭЭ

№	Асуулгын бүтэц	Авбал зохих оноо	Үнэлсэн оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12	91.6%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10	100%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6	100%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6	100%
5	Эрсдэлийн удирдлага	8	8	100%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин, нэмэгдэл	6	5	83.3%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8	100%
8	Компанийн соёл	6	6	100%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	9	90%
Нэгдсэн дүн		72	70	97,2%

2024 оны жилийн байдлаар компанийн засаглалын кодексийн үнэлгээг 97,2%-тай дүгнэгдсэн.

3.3. ОЛОН УЛСЫН ISO 9001:2015 СТАНДАРТ МАГАДЛАН АУДИТ



2024 оны хувьд Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартын хэрэгжилтийг сайжруулах талаар Магадлан-I аудитын шалгалтаар өгсөн зөвлөмжийн хүрээнд төлөвлөгөө гарган Гүйцэтгэх захирлын 2024 оны А/07 тоот тушаалаар батлуулан мөрдөн ажиллалаа.

Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартын хэрэгжилтийн шаардлагад нийцсэн үйл явцууд болон тэдгээрийн харилцан үйлчлэл бүхий менежментийн тогтолцоог бий болгож, хэрэгжүүлж, хадгалж, үргэлж сайжруулах процессыг ханган ажилласан.

Үүний үр дүнд 2024 оны 12 сард Бүгд Найрамдах Франц Улсын Афнор группээс компанийн чанарын менежментийн тогтолцооны ISO9001:2015 стандартын хэрэгжилтэд Магадлан II аудитыг хийж гүйцэтгэн, том болон жижиг үл тохирол илрээгүй тул магадлах аудитын үр дүнгээр компани дээрх менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын гэрчилгээг үргэлжлүүлэн хадгалахаар болсон.



3.4. ТОГТВОРТОЙ БАЙДАЛ-БОНЗ

НУБ-ЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД

Компанийн итгэмжлэн удирддаг “Нийслэлийн хөгжлийн сан Хувийн ХОС ТЗК ХХК”, “Нийслэлийн ногоон сан Хувийн ХОС ТЗК ХХК” болон “Нийслэлийн гарааны бизнесийг дэмжих сан Хувийн ХОС ТЗК ХХК” нь НУБ-ын тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдан

ажилладаг бөгөөд уг 3 сан нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн дараах зорилтуудын хүрээнд хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийг дэмжин ажилладаг.

3. Эрүүл мэндийг дэмжих
4. Чанартай боловсролыг дэмжих
6. Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах
7. Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх
8. Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих
9. Инновац болон дэд бүтцийг хөгжүүлэх
11. Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих
13. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг багасгах
15. Хуурай газрын экосистемийг хамгаалах



НОГООН ОФФИС



Бид компанидаа ногоон орчныг бий болгох цаашлаад ногоон худалдан авалтыг дэмжих, ногоон хэрэглээг хэвшүүлэх, ногоон сэтгэлгээг төлөвшүүлэхэд Нийслэлийн ногоон сангийн болон БОНЗ-ын менежер сургалтыг ажилтнуудад хийж ажиллаж байна.



Эрчим хүчний хэрэглээ нь хүлэмжийн хийн ялгарлыг их хэмжээгээр нэмэгдүүлж, уур амьсгалын өөрчлөлтөд голлох сөрөг нөлөөг үзүүлдэг. Иймд бид дотооддоо эрчим хүчийг хэмнэхэд анхаарч, барилгын дулаан алдагдлыг бууруулж, өдөр бүр ажлаас тарахад цахилгаан хэрэгсэл, өрөөнүүдийн гэрэл, уртасгагч, залгуур зэргийг унтрааж салгасан эсэхийг хянах хяналтын хуудсыг боловсруулж, бүртгэлжүүлсэн.

Байгууллагуудын салбар бүрийн онцлогоос хамааран хог хаягдлын төрөл өөр байх бөгөөд түүнд хамаарах хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх нь зүйтэй. Компанийн хувьд аюултай хортой хог хаягдал гаргадаггүй бөгөөд ихэвчлэн цаасны хог хаягдал гаргадаг тул үүнийг дахин ашиглах, дахин боловсруулах, багасгах буюу 3R-г хэрэгжүүлэхээр зорин ажилласан.

БОНЗ-ЫН ТАЛААРХ СУРГАЛТ, ХӨГЖИЛ

Байгаль орчин, нийгэм, засаглалын тайлагналыг хэрэгжүүлж эхлэхийн тулд компанид байгаль орчин, нийгэм, засаглалыг хариуцсан ажилтан, түүнийг чадавхжуулах хөтөлбөр, компанийн нийт ажилтнууд нь байгаль орчин, нийгэм, засаглалын талаарх мэдлэг ойлголтыг

эзэмшсэн байх зэрэг нь чухал нөлөөтэй тул эдгээр ажлуудыг үе шаттайгаар хийхээр төлөвлөн ажиллав.

Монгол Улсын хувьд зөвхөн банкны салбарт тогтвортой байдлын тайлагналын удирдамж боловсруулагдсан бөгөөд сүүлд Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ), Монголын хөрөнгийн бирж (МХБ), Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоо (ТоС Холбоо), Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК), НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ), Монгол Улс дахь НҮБ-ын Суурин зохицуулагчийн газар, НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр (UNEP), Тогтвортой байдлын төлөөх санхүүгийн төвүүдийн олон улсын сүлжээ (UNDP FC4S) хамтран, Даян дэлхийн байгаль орчны сан (GEF) болон НҮБ-ын ТХЗ-ын хамтарсан сан (UN Joint SDG Fund)-ийн дэмжлэгтэйгээр бүх компаниудад зориулсан удирдамжийг боловсруулж гаргасан байна. Үүний хүрээнд БОНЗ, тогтвортой байдлын тайлагнал нь бүх компаниудын хувьд тайлагнах ёстой ажлуудын нэг болсон. Иймээс БОНЗ-ын тайлагналын ач холбогдол, чиг хандлага, загварууд болон шинээр боловсруулагдсан тогтвортой байдлын тайлагналын удирдамжийн талаарх мэдээллийг нийт ажилтнуудад хүргэсэн.

3.5. САНХҮҮГИЙН ХЭРЭГСЭЛ БОЛОН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН САН ХУВИЙН ХОС ТЗК ХХК

Нийслэлийн дунд болон урт хугацааны бодлогын хүрээнд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэгч байгууллагуудад хөрөнгө оруулалт хийхээр зорьж байна.

1. Улаанбаатар бонд

Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 48 дугаар тогтоолоор Нийслэлийн дотоод үнэт цаас гаргахыг дэмжиж “Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль”, “Шинэ сэргэлтийн бодлого” болон “Нийслэлийн дунд хугацааны бодлогын баримт бичиг”-үүдэд туссан нийслэл Улаанбаатар хотын дэд бүтцийг хөгжүүлэх төсөл арга хэмжээг санхүүжүүлэх зорилгоор дотоодын зах зээлд үнэт цаас гаргахыг зөвшөөрсөн. Үүнтэй холбоотой Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 249 дүгээр тогтоолоор “Нийтэд санал болгон гаргаж буй өрийн хэрэгслийг бүртгэх”-ийг зөвшөөрснөөр Монголын хөрөнгийн зах зээл дээр цоо шинэ санхүүгийн хэрэгсэл бүртгэгдэж, 2024 оны 06 сарын 20-ны өдөр анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлэн амжилттай санхүүжилтийг татан төвлөрүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 201 дүгээр тогтоолын хавсралтад заасны дагуу 300,000,000,000 /гурван зуун тэрбум/ төгрөгөөр Бөөрөлжүүтийн цахилгаан станцын төслийг санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн ба энэхүү төслийн санхүүжилтийг “Нийслэлийн Хөгжлийн Сан Хувийн ХОС ТЗК” ХХК-иар дамжуулан хийх санхүүгийн схемийг боловсруулан, амжилттай ажиллалаа.

2. Бөөрөлжүүтийн цахилгаан станцын төсөл

Төвийн бүсийн эрчим хүчний системийн оргил ачаалал 2022 онд 1469 мвт хүрч өмнөх оноос 6 хувиар, 2023 онд 1636 мвт хүрч 11.3 хувиар өсөж, эрчим хүчний хэрэглээ 200-250 мвт-аар хэтэрснээс үүдэлтэй нийлүүлэлтийг хязгаарлах нөхцөл байдалд хүрсэн. Цаашид өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчний хэрэглээг хангах, иргэдийн ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэх, Улаанбаатар хотод хэрэгжих томоохон төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд эрчим хүчний суурь хэрэгцээг хангах шаардлага тулгараад байна. Тус төслийг Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр санхүүжүүлснээр Нийслэл төдийгүй улс орны эрчим хүчний найдвартай байдлыг хангах стратегийн ач холбогдол бүхий хөрөнгө оруулалт болж байна.

Бөөрөлжүүтийн цахилгаан станцын өсөл нь Улаанбаатар хотоос 120 км зайд Төв аймгийн Баянжаргалан сумын нутагт орших Бөөрөлжүүтийн хүрэн нүүрсний ордыг түшиглэн, 600 мвт-ын цахилгаан станцыг барьж байгуулах төлөвлөгөөтэй бөгөөд эхний ээлжийн 150 мвт-ын цахилгаан станцыг 2024 оны 12 дугаар сард ашиглалтанд оруулж, 2 дахь ээлжийн 150 мвт-ын цахилгаан станцыг 2025 оны 9 дүгээр сард ашиглалт оруулахаар төслийг хэрэгжүүлэгч ажиллаж байна. Цаашид үе шаттайгаар 2028 он хүртэл 600 мвт-ын хүчин чадал бүхий станц болох төлөвлөлттэй.

Төсөл хэрэгжүүлэх явцад эхний ээлжийн 150 МВт блокийн барилга угсралтын нүүрс татах туузан дамжуургын С6 хэсэгт 2024 оны 11-р сарын 17-ны өдөр галын осол гарсан хэдий ч галын ослоос үүдсэн эвдрэлийг шуурхай засварласан.

2024 оны 5-р сард 1.Зуухны даралтын гидростатик туршилт /том туршилт/, 2.Хими ус бэлтгэлийн усан туршилт /жижиг туршилт – Гидростатик туршилтын өмнөх/ гэсэн туршилтуудыг хийж амжилттай болсны дагуу дээрх

Зураг: Цахилгаан станцын 1-р блок



төлөвлөгөөт хугацаандаа төслийн ажил дуусах нь баталгаажиж, 1-р блокийн ерөнхий гүйцэтгэл 99,96%-тайгаар 2024.12-р сард төвийн бүсийн эрчим хүчний сүлжээнд 150МВт эрчим хүч амжилттай нийлүүлж эхэлсэн.

Зураг: Цахилгаан станцын 2-р блокийн явцын зураг



Үнэт цаас гаргагч нь 2-р блок буюу дараагийн 150 МВт барилгын ажлыг 2023 оны сүүлээр эхэлсэн. Өнгөрсөн 6-р сарын байдлаар үндсэн барилга болон зуухны карказ угсралт, суурийн ажил хийгдээд байна. Түүнчлэн 2-р блоктой хамааралтай туслах барилга, тоног төхөөрөмжийн угсралтын ажлыг эхлүүлсэн. 2-р блокийг 2025 оны 10 сард дуусгахаар төлөвлөж байна. Цахилгаан дамжуулах агаарын шугам Бөөрөлжүүтийн цахилгаан станцыг төвийн бүсийн эрчим хүчний систем рүү холбох Бөөрөлжүүт - Багануур чиглэлийн 71.5км ЦДАШ-ын ажил дууссан.

3. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа

Бөөрөлжүүтийн цахилгаан станцын төсөл нь дараах Нийслэлийн бодлого, стратегид нийцэж байна. Үүнд:

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого:

4.2.8. Цахилгаан станцуудыг өргөтгөж, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, шинэ эх үүсвэрийн барьж, цахилгаан эрчим хүчээр дотоодын хэрэгцээг бүрэн хангасан байна.

8.1.6. Эрчим хүчний бие даасан нэгдсэн системтэй болж, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийг хоршин ашиглах ухаалаг тогтолцоонд шилжүүлж, эрчим хүч экспортлогч болсон байна.

9.3.6. Хотын гудамж замын иж бүрэн сүлжээг бий болгоно.

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл:

9.10. Эрчим хүчний ашиглалтын үр ашгийг өсгөж, дэд бүтцийг өргөжүүлэн, технологийн шинэчлэл хийж, хүн амыг тогтвортой эрчим хүчээр хангана.

9.11. Дулааны эрчим хүчний дотоодын хэрэгцээг бүрэн хангах эх үүсвэрийн чадлын нөөцийг бий болгоно.

Иймд Бөөрөлжүүтийн цахилгаан станцын төсөл сангийн Монгол Улсын тогтвортой үзэл баримтлал, Улаанбаатар хотын хөгжлийн төлөвлөгөө, чиглэлд нийцсэн, нийгэм эдийн засгийн үр ашигтай, дунд болон урт хугацааны төсөл, төслийн хэрэгжүүлэлтэд мэргэжлийн хөрөнгө оруулагчидтай хамтран хөрөнгө оруулах үндсэн зорилгод нийцэж байна.

“Бөөрөлжүүтийн цахилгаан станц” бонд нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.6 дах заалтад заасан “үнэт цаасны зах зээлд нээлттэй арилжаалагддаггүй компанийн өрийн хэрэгсэл” тул сангийн хөрөнгө оруулах боломжит хэрэгсэл мөн болно.

Бөөрөлжүүтийн цахилгаан станцын төсөл нь “эрчим хүч”-ний салбарт хэрэгжиж буй төсөл тул сангийн хөрөнгө оруулалтын салбарын хязгаарлалтад нийцнэ.

Сангийн хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичгийн 5.4 дүгээр заалтад “Нийслэлийг хөгжүүлэх бодлогын баримт бичигт тусгагдсан мөн нэгж эрх эзэмшигчдийн хурлаар хөрөнгө оруулахаар шийдвэрлэсэн тохиолдолд энэхүү бодлогын баримт бичигт заасан санхүүгийн хэрэгсэлд дээр дурдсан сангийн активын бүтэц, хязгаарлалтыг үл харгалзан хөрөнгө оруулж болно” хэмээн заасан. Уг бөөрөлжүүтийн цахилгаан станцын төсөл нь

Нийслэлийг хөгжүүлэх холбогдох бодлого, стратегид нийцэж байгаа бөгөөд сангийн нэгж эрх эзэмшигчдийн III хурлаар хөрөнгө оруулалт хийхээр шийдвэрлэсэн тул сангийн хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт нийцэж байгаа юм.

Тус төслийн нийцэл, Улаанбаатар бондтой холбоотой Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол шийдвэр болон Нийслэлийн Засаг даргын А/735, А/762 дугаар тоот тогтоолуудыг үндэслэн “Бөөрөлжүүтийн цахилгаан станц” бондод хөрөнгө оруулах танилцуулга, санал, төслийн эрсдэлийн үнэлгээ зэргийг Нэгж эрх эзэмшигчдийн хуралд танилцуулан хөрөнгө оруулалтыг хийж гүйцэтгэсэн.

Хөрөнгө оруулалтаар “Бөөрөлжүүтийн цахилгаан станц”-ийн үйл ажиллагаа амжилттай үргэлжилж байгаа бөгөөд туршилт тохируулга хийгдэж, 2024 оны 12 сарын 26-ны өдрөөс эхлэн цахилгаан дамжуулалт хийгдэж эхэлсэн. Мөн бондын хүүгийн төлбөрийг графикийн дагуу төлж, хөрөнгө оруулалтын эрсдэлгүй төлөвт байна.

Мөн цахилгааны эх үүсвэр болох цахилгаан эрчим хүчний салбар дахь “Тосон энерги” ХХК-ийн “Дулааны цахилгаан станцын хөрөнгө оруулалт”, “Шунхлай” ХХК-ийн “Дизель түлшний” эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн хөрөнгө оруулалт зэрэгт хувь нэмрээ оруулан ажиллаж байна. Монгол Улсын засгийн газраас 2025 оныг “Нийслэлийн бүтээн байгуулалтын жил”, Нийслэлийн засаг даргын тамгын газраас 2025 оны “Бүтээн байгуулалтын жил” тус тус болгон зарласантай холбогдуулан сангаас нийслэлийн хөгжлийг дэмжсэн болон нийслэлд хэрэгжүүлэх мега төслүүдэд хөрөнгө оруулалт хийх зорилгоор хөрөнгө татан төвлөрүүлэх, хөрөнгө оруулалт хийх бодлого баримтлан ажиллаж байна.

НИЙСЛЭЛИЙН НОГООН САН ХУВИЙН ХОС ТЗК ХХК

Нийслэлийн ногоон сангийн хувьд Нийслэлийн Засаг Дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт 2030, Нийслэлийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2040, Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилго 2030 зэрэг баримт бичгүүдэд нийцсэн төсөл хөтөлбөрүүдийг судлан, шалгуур хангах төсөлд хөрөнгө оруулалт хийхээр ажилладаг.

Монголын ногоон санхүүгийн корпорацийн төсөл

Монголын ногоон санхүүгийн корпорацын үйл ажиллагааг эхлүүлэхэд дэмжлэг үзүүлэхээр Нийслэлийн зүгээс хүлээсэн 18.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг 2023 оны 9 сарын 28 өдөр Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд оруулж батлуулсан.

Цаашид Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Нийслэлийн өмчит Улаанбаатар Хөрөнгө оруулалт, Менежмент ҮЦК ХХК-д төлөөлөх итгэмжлэл авах, үлдсэн хөрөнгө оруулалтыг шийдэх, ногоон санхүүжилтийн корпорацийн бичиг баримтад хуулийн нийцэл хийх, мөн тус төслийг Нийслэлийн Ногоон сан Хувийн ХОС ТЗК ХХК-р дамжуулан хэрэгжүүлэхэд чиглэн судалгааны ажлыг үргэлжлүүлэн хийж, танилцуулга хийгдсэн.

Улаанбаатар хотын орлогод нийцсэн орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл төсөл

Нийслэлийн Засаг Даргын Тамгын газар нь Азийн хөгжлийн банк, уур амьсгалын ногоон сангийн санхүүжилтээр “Улаанбаатар хотын ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл”-ийг хүртээмжтэй ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх, орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжүүлж байна.

Уг төсөл нь байгаль, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд өртөмтгий, стандартын шаардлага хангахгүй, агаар, орчныг ихээр бохирдуулж буй Улаанбаатар хотын гэр хорооллын 100 га талбарыг дахин төлөвлөн 10.000 айлын орлогод нийцсэн эко орон сууц барих замаар нүүрсхүчлийн хийн ялгарал багатай, уур амьсгалтын өөрчлөлтөд тэсвэртэй, амьдрахад таатай эко хорооллууд болгон өөрчлөх тогтвортой, цогц шийдлүүдийг агуулсан томоохон хэмжээний төсөл бөгөөд Алсын хараа 2050 бодлогын баримт бичгийн доорх зорилтуудад чиглэсэн.

- Зорилт 3.2. Өрх, гэр бүлийн орлогод нийцсэн орон сууцаар хангах нөхцөлийг бүрдүүлнэ;
- Зорилт 9.2. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан, хүлэмжийн хийн ялгарал багатай ногоон технологи бүхий амьдралын таатай орчинтой хот болно;
- Зорилт 9.3. Орон зайн оновчтой төлөвлөлт бүхий суурьшлын зөв тогтолцоотой, эрчимтэй хөгжиж байгаа дагуул хотуудтай олон улсад өрсөлдөгч метрополитан болж хөгжинө.

Тус төслийн баримт бичгийн бүрэлдэхүүн хэсэг 2-т “Гэр хорооллын дэд төвүүдэд нүүрс хүчлийн хийн ялгарал багатай орлогод нийцсэн ногоон орон сууцны эко хороолол байгуулах” зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд санхүүжилтийг Нийслэлийн ногоон сангаар дамжуулан хийх

тохиолдолд сангийн удирдлага үйл ажиллагааг зохион байгуулж ажиллах, байгууллагын чадавх нөөц бололцоогоор сангийн хөрөнгийг төслийн баримт бичигт заасан зориулалтын дагуу удирдаж, үр дүнд хүргэх, эргэн төлөлтийг Сангийн яаманд төвлөрүүлж ажиллах боломжтой эсэх талаар судлан үзэж, эдийн засгийн тооцоолол болон холбогдох саналыг боловсруулан ажилласан.

Мөн манай компанийг тус төслийг хэрэгжүүлэх хууль эрх зүйн нийцэл, санхүүгийн туршлага, чадвартай эсэхийг үнэлэх зорилгоор Азийн Хөгжлийн Банкнаас 2023 оны 11-р сард “Financial Management Assessment Questionnaire” буюу үнэлгээний асуулгыг ирүүлсэн бөгөөд тус асуулгад хариулж, Хөрөнгө оруулалтын менежментийн компани болон хөрөнгө оруулалтын сангуудын санхүүгийн тайлан, шаардлагатай дүрэм, журам, баримт бичгүүдийг бүрдүүлж хүргүүлсэн.

Азийн хөгжлийн банк хууль эрх зүйн болон санхүүгийн туршлага, чадварын хянан нийцүүлэлтийг хийж, урьдчилсан байдлаар манай компанийг төслийг хэрэгжүүлэх боломжтой хэмээн үнэлсэн.

Мөн 2024 оны I болон II улиралд Азийн Хөгжлийн Банкны төслийн нэгжтэй хамтран ажиллаж, Азийн Хөгжлийн Банкнаас нэмэлтээр шаардсан компанийн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, баримт бичиг болон компанийн лавлагаа, тодорхойлолтуудыг хүргүүлж ажилласан.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 108 дугаар тогтоолоор “Эко хороолол ба орлогод нийцсэн орон сууцны сан”-г үүсгэн байгуулах болон хөрөнгө оруулалтын санхүүжилтийн схемд “Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт менежмент ҮЦК” ХХК-ийг оролцуулж, төслийг “Ди Би Эм ассет менежмент ҮЦК” ХХК-тай хамтран хэрэгжүүлэхийг Нийслэлийн Засаг даргад даалгасан.

2024 оны III болон IV улиралд “Уур амьсгалын ногоон сан”-ийн санхүүжилтээр “Азийн хөгжлийн банк”-ны хяналтан дор “Улаанбаатар хотын ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл”-ийг хүртээмжтэй ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх, орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилго бүхий хамтарсан “Эко хороолол ба орлогод нийцсэн орон сууцны сан” хувийн ХОС-ыг үүсгэн байгуулах, “Нийслэлийн Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төслийн нэгж”-тэй хамтран ажиллах талаар “Ди Би Эм Ассет менежмент” ҮЦК ХХК-тай уулзалт хийж, төслийг хамтын удирдлагаар хангаж ажиллаж нэгж эрх эзэмшигчээр ажиллах шийдвэрт хүрч байна.

Бусад

Ногоон төсөлд хөрөнгө оруулалт хийх зорилгоор доорх компаниудтай хамтран ажиллахаар судалгааны ажлыг эхлүүлээд байна. Үүнд:

Төсөл хэрэгжүүлэгч		Үйл ажиллагааны чиглэл
	Олон Улсын байгаль хамгаалах сан	“Эрүүл Ой” төслийн хүрээнд АНУ-ын ойн шавжийн мэргэжилтнүүдтэй хамтран ойн шавжийн тэмцлийн ажлын бэлдмэл болон техникийн ажлыг гүйцэтгэж онгоц болон үүргэн шүршигчийн норм тунг тохируулах, баталгаажуулах ой хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй компани юм.
	Ойм ногоон урлан	03/03/2005 онд “Dream Green service” нэртэйгээр Улаанбаатар хотын ногоон байгууламж, мандлын цэцгийг тарьж эхэлснээр өнөөдрийн Ойм Ногоон урлан бий болсон. 2018 оноос “Ойм ногоон урлан” гэх тодотголтой, өөрсдийн өнгө аясыг шингээсэн салбар дэлгүүрүүдээ нээсээр одоо Улаанбаатар хотод таван салбар дэлгүүртэй, үйл ажиллагаа явуулж байна.

НИЙСЛЭЛИЙН ГАРААНЫ БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ САН ХУВИЙН ХОС ТЗК ХХК

Гарааны бизнесийг дэмжих сангаас “Ур чадвар, шинэлэг санаа”-нд тулгуурлан гарааны болон санхүүгийн дэмжлэг олгох, бизнесээ тогтвортой эрхлэх боломжоор нь дэмжих, байнгын ажлын байртай болгох зорилготойгоор хөрөнгө оруулалтыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байгаа бөгөөд доорх гарааны бизнесийн нэгдэл бүхий компаниудтай уулзалтуудыг зохион байгуулж, хамтын ажиллагааны төлөвлөгөө боловсруулахаар ажиллаж байна.

Тодруулбал Бизнес инкубатор төвүүд, ЖДҮ дэмжих төвүүд, Бизнес хөгжлийг дэмжих төвүүд, Аж ахуй эрхлэлтийн сургалтын төвүүд, Мэргэжлийн зөвлөгөө өгөх төвүүдээс дараах байгууллагуудтай анхан шатны уулзалтуудыг зохион байгуулаад байна. Үүнд:

- InnoHub - МОНОС компанийн Старт-Ап хурдасгуур
- MStars – MCS компанийн төсөл бойжуулагч

- BNI – Бизнес нетворкинг интернэшнл буюу Олон төрлийн бизнесийн нэгдэл бүхий холбоо

НИЙСЛЭЛИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН САН ХУВИЙН ХОС ТЗК ХХК

Нийслэлийн Эрсдэлийн Удирдлагын Сан Хувийн ХОС ТЗК ХХК нь эрсдэлийн менежмент хийх зорилгоор “Нийслэл дэх гамшгийн эсрэг ажил, үйлчилгээ явуулж буй төслүүдийг дэмжин хөрөнгө оруулалт хийх буюу гамшгийн эрсдэл бүхий нөхцөл: Үер, гал түймэр, зуд, газар хөдлөлт, салхи шуурга, ургац алдалт, утааны эсрэг, хөрсний бохирдол, тоосжилтыг бууруулах, нүүрсхүчлийн хийг багасгах, мод үржүүлэг, цөлжилтөөс сэргийлсэн үйл ажиллагааг дэмжих, эм тариа, малын гоц халдварт өвчлөл, онцгой, хог хаягдал, томуу томуу төст өвчлөлийн эсрэг эм бэлдмэл зэрэг чиглэлд чиглэсэн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуй нэгжүүдэд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд заасан хэрэгслүүдээр хөрөнгө оруулахыг зорьж, судалгаа шинжилгээ хийж байна.

Компанийн хөрөнгийг үр дүнтэй удирдах зорилгоор сангийн хөрөнгө оруулалтын оновчтой багцыг тодорхойлон, хөрөнгө оруулах боломжтой санхүүгийн хэрэгслүүдийн судалгааг үргэлжлүүлэн ажиллаж байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГУУДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛСАН САНХҮҮГИЙН ХЭРЭГСЛҮҮД

Хөрөнгө оруулалт хийсэн хэрэгсэл	Хөрөнгө оруулалт хийсэн хугацаа	Хөрөнгө оруулалт дуусах хугацаа	Хөрөнгө оруулсан үнийн дүн	Хуримтлагдсан өгөөжийн хэмжээ	Эргэн төлөлт
Нийслэлийн хөгжлийн сан					
Бөөрөлжүүт цахилгаан станц бонд /14,44%/	2024.06.23	2027.06.23	300,000,000,00	22,787,506,849.30	Хэвийн
МИК бонд /18%/	2024.04.17	2024.04.05	300,000,000	38,317,808.22	Хэвийн
Шунхлай бонд /17%/	2024.12.05	2025.06.05	900,000,000	12,156,164.38	Хэвийн

Жем тосон энерги бонд /18%/	2024.12.16	2025.06.16	500,000,000	3,945,205.48	Хэвийн
Покет бонд /18%/	2024.10.18	2025.10.18	200,000,000	7,397,260.27	Хэвийн
Инвектор багцын хувьцаа	2023.08.01	2024.05.16	250,000,000	28,270,735.41	Дууссан
Нийслэлийн эрсдэлийн удирдлагын сан					
МИК бонд /18%/	2024.04.04	2025.04.04	100,000,000	12,871,232.88	Хэвийн
Лэнд бонд /18%/	2024.03.18	2025.09.17	100,000,000	14,252,054.79	Хэвийн
Бичил глобус ББСБ хаалттай бонд Транч 2 /19%/	2024.03.18	2025.03.18	150,000,000	22,565,753.42	Хэвийн
Актив хаалттай бонд /19%/	2023.05.29	2024.11.29	150,000,000	42,633,705.50	Дууссан
ТиДиБи лизинг Мирай бонд /17%/	2023.07.31	2024.06.26	100,000,000	15,531,876.71	Дууссан
REIT хаалттай бонд /18,7%/	2023.08.01	2024.01.20	100,000,000	8,811,054.79	Дууссан
Нийслэлийн гарааны бизнесийг дэмжих сан					
МИК бонд /18%/	2024.04.15	2025.04.15	100,000,000	13,414,698.63	Хэвийн
Покет бонд /18%/	2024.10.18	2025.10.18	100,000,000	3,698,630.14	Хэвийн
Бичил глобус бонд /19%/	2024.03.18	2025.03.18	174,335,883	22,565,753.43	Хэвийн

3.4 ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

Манай компани нь дотоод хяналтын тогтолцоонд “Хамгаалалтын 3 шугам” загварын дагуу зохион байгуулалтыг хийж, үйл ажиллагаагаа сайжруулан ажиллаж байна. Энэ загвар нь шат шатны удирдлагууд өдөр тутмын төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах, хянах, зохицуулах үндсэн чиг үүргүүдээ хэрэгжүүлэн ажиллахад ач холбогдолтой.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Манай компани ТУЗ-өөс баталсан бүтэц зохион байгуулалтын хүрээнд Дотоод хяналт, эрсдэлийн албанд Ахлах хянан шалгагч, Ахлах хуульч болон Эрсдэлийн менежерийн 3 хүний орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. Бид болзошгүй эрсдэлийг урьдчилан тодорхойлж, түүнд үр дүнгийн шинжилгээ хийж эрсдэлийг удирдан, эрсдэлийн зохимжит түвшнийг тодорхойлж, компанийн өдөр тутмын тогтвортой байдлыг хангахуйц эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэн үйл ажиллагаандаа хэвшүүлэн ажиллаж байна.

Бид дээрх зорилгыг компанийн тогтолцоонд бодитоор хэрэгжүүлэхийн тулд Эрсдэл ба боломжийг удирдах журмыг сайжруулан боловсруулж, Гүйцэтгэх захирлаар батлуулан дараах арга, аргачлалуудыг нарийвчлан тодорхойлж, журмаараа зохицуулдаг болсон.

- Хөрөнгө оруулалтын сангуудын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал, эрсдэлийн аппетит
- Хөрөнгө оруулах санхүүгийн хэрэгсэл, төсөл хөтөлбөрүүдийн эрсдэлийг үнэлгээ хийх арга аргачлал
- Компанийн үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэх болон дүгнэх аргачлал

2024 оны 3 дугаар сард Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөг дараах 4 зорилтын хүрээнд 10 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр батлуулсан бөгөөд төлөвлөгөөний гүйцэтгэл 95%-тай байна. Төлөвлөлтийг дараах хүрээнд хийсэн. Үүнд:

1. Сангуудын эрсдэлийг үнэлэх, илэрсэн эрсдэлийг бууруулах
2. Хөрөнгө оруулалтын эрсдэлийг үнэлэх
3. Компанийн эрсдэлийг үнэлэх, илэрсэн эрсдэлийг бууруулах
4. МУТСТХ-ийн хэрэгжилтийг хангах

Дээрх төлөвлөгөөний хүрээнд дараах байдлаар эрсдэлийн үнэлгээ болон бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлж ажилласан.

Компанийн үйл ажиллагааны эрсдэл

- Үйл ажиллагааны эрсдэлийн журам, Эрсдэл ба боломжийг удирдах журмыг нэгтгэн ТУЗ-ын гишүүдээс өгсөн саналуудыг тусган гүйцэтгэх захиралд танилцуулсан.
- 2024.05.07-нд компанийн үйл ажиллагаанд эрсдэл боломжийн үнэлгээ хийж, ноцтой эрсдэлүүдийг бууруулах төлөвлөгөө гарган ажилласан.
- Жилийн эцсийн байдлаар эрсдэлийн үлдэгдлийг гарган удирдлагад танилцуулан ажилласан..

Хөрөнгө оруулалтын сангийн эрсдэлийн үнэлгээ

- 2023 оны жилийн эцсийн байдлаар 4ХОС-ийн эрсдэлийн үнэлгээ хийсэн..
- 2024 оны 3-р улиралд 4 сан тус бүр дээр SWOT шинжилгээ хийсэн.
- Сангийн эрсдэлийн аппетитийг боловсруулан журамд тусгасан.
- 2024 оны жилийн эцсийн байдлаар 4 сан тус бүр дээр эрсдэлийн үнэлгээ хийсэн

Хөрөнгө оруулах төсөл хөтөлбөр, санхүүгийн хэрэгслийн эрсдэлийн үнэлгээ

- Хөрөнгө оруулах 9 санхүүгийн хэрэгсэлд эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийж эрсдэлийн зөвлөлийн хуралд танилцуулсан.
- Бөөрөлжүүтийн цахилгаан станцын төслийн эрсдэлийн үнэлгээг хийж НХС-ын нэгж эрх эзэмшигчдийн хуралд танилцуулсан.

Түүнчлэн компанийн эрсдэлийн үнэлгээг үйл ажиллагааны эрсдэл болон хөрөнгө оруулах төсөл хөтөлбөрийн эрсдэл гэж ангилан үнэлдэг ба төсөл хөтөлбөрийн эрсдэлийн дүгнэлтийг Эрсдэлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж хөрөнгө оруулах эсэх шийдвэр гаргаж байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ЭРСДЭЛ

Бид хөрөнгө оруулах төслийн эрсдэлийг үнэлэхдээ тухайн төслийн үйл ажиллагааны онцлог, хэрэгцээ шаардлага, зах зээлийн хандлагад тулгуурлан эрсдэлийн шинжилгээ, үнэлгээ хийдэг ба Сангийн хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт заасан хөрөнгө оруулах хязгаарлалтын дагуу 2024 онд ТУЗ, НЭЭ-ийн хурлаар 1 асуудлыг, компанийн Эрсдэлийн зөвлөл нийт 6 удаа хуралдаж 13 асуудлыг тус тус хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

ЭРСДЭЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ЖАГСААЛТ

№	Огноо	Хэлэлцсэн асуудал	Шийдвэр гаргасан	Гарсан шийдвэр
1.	2024.02.05	1. Сангуудын мөнгөн хөрөнгө, хөрөнгө оруулалтын мэдээлэл 2. ХОМК-ийн мөнгөн хөрөнгө, хадгаламжийн мэдээлэл	Эрсдэлийн зөвлөл	1. НГБДС болон НЭУС-ын мөнгөн хөрөнгөд 1 сарын хугацаатай шинэ хадгаламжийн данс нээж чөлөөт мөнгөн хөрөнгийг байршуулах 2. ХОМК-ийн мөнгөн хөрөнгийг Кадитрон банканд 12 сарын хугацаатай жилийн 14.6% хүүтэй 3 тэрбум төгрөгийг байршуулахаар тус тус шийдвэрлэсэн.
2.	2024.03.14	1. Лэнд бондын танилцуулга 2. Глобал таун бонд 3. BG бондын танилцуулга	Эрсдэлийн зөвлөл	1. Лэнд бондыг НЭУС-аас 18 хувийн хүүтэй, 18 сарын хугацаатай, 100,000.00 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 1000 ширхэг бондыг 2. BG бондыг НГБДС-аас 19 хувийн хүүтэй, 12 сарын хугацаатай, 1,000,000.00

				төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 15 ширхэг бондыг тус тус худалдан авахаар шийдвэрлэсэн.
3.	2024.04.09	МИК бондын танилцуулга	Эрсдэлийн зөвлөл	НХС, НГБДС болон НЭУС-аас МИК бондыг 18 хувийн хүүтэй, 12 сарын хугацаатай, 100,000.00 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 5,000 ширхэг бондыг тус тус худалдан авахаар шийдвэрлэсэн.
4.	2025.05.02	1. ХОМК-ийн мөнгөн хөрөнгө, хадгаламжийн танилцуулга 2. Сангуудын хөрөнгө оруулалтын тухай мэдээлэл	Эрсдэлийн зөвлөл	1. Голомт болон Худалдаа хөгжлийн банканд шинээр хадгаламж нээхээр 2. НХС болон НГБДС-аас эзэмшиж буй Инвескор багцын хувьцааг сунгахаар 3. НЭУС-аас эзэмшдэг Актив бондын хугацааг сунгахаар тус тус шийдвэрлэв.
5.	2024.06.22	Бөөрөлжүүт цахилгаан станцын бондын танилцуулга	НЭЭ-ийн хурал	Бөөрөлжүүтийн цахилгаан станц бондод 14.44% хүүтэйгээр 300 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр шийдвэрлэв.
6.	2024.12.06	1. Шунхлай бондын танилцуулга 2. Тосон энерги бондын танилцуулга 3. Мацуяа бондын танилцуулга	Эрсдэлийн зөвлөл	1. Шунхлай бонд 900 сая төгрөгөөр хөрөнгө оруулалт хийх 2. Тосон энерги бонд 500 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийх 3. Харилцах дансны үлдэгдлийг системийн банканд байршуулахаар шийдвэрлэв
7.	2024.12.27	1. Хушхан бондын танилцуулга 2. Покет бондын танилцуулга	Эрсдэлийн зөвлөл	Хушхан болон Покет бондод хөрөнгө оруулалт хийхээр шийдвэрлэв.

КОМПЛАЙНСЫН ХЯНАЛТ, МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ

СЗХ-ны 2022 оны 276 дугаар тогтоолоор батлагдсан “Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4 дэх заалтын дагуу компани Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт болон Комплайнсын хяналтыг хэрэгжүүлэх нэгж, эсхүл хариуцсан ажилтантай байх шаардлага тавигддаг. Энэхүү шаардлагын дагуу компани “Комплайнсын үйл ажиллагааны журам” болон “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр”-ийг батлан, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Компанийн хувьд комплайнсын үйл ажиллагааг хэрэгжүүлэх бүтцийг ТУЗ-ийн хурлаар батлуулж, Комплайнсын хяналтын үйл ажиллагааг зохион байгуулж, компанийн дотооддоо мөрдөх бодлогын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг “Компанийн засаглалын кодекс”-ийн зарчимд нийцүүлэн баталгаажуулж, үйл ажиллагаандаа нэвтрүүлж, хэвшил болгох цогц баримт бичгийг батлан мөрдүүлж, хууль тогтоомж, дүрэм журам хаана хэрхэн зөрчигдөж байгааг илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, хууль, дүрэм зөрчсөний улмаас компанид учирч болох алдагдал, хохирлыг багасгаж, үйл ажиллагааг саадгүй амжилттай явуулахад дэмжлэг үзүүлэх тогтолцоог бүрдүүлэн, компанийн үйл ажиллагаа болон компанид мөрдөгдөх дүрэм, журам, заавар нь холбогдох хууль тогтоомж, эрх бүхий зохицуулах байгууллагаас баталсан дүрэм журам, стандартад нийцүүлэн хэрэгжүүлж, буй эсэхэд хяналт тавих үйл явцыг хэрэгжүүлэн ажиллаж байна

Түүнчлэн “Комплайнсын эрсдэл” гэж компанийн эрхэлж буй үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж дүрэм, журам ёс зүйн хэм хэмжээ болон дотоод бодлогыг дагаж мөрдөөгүйн улмаас үүсэн гарах бизнесийн алдагдал, хохирол, нэр хүндийн асуудал, үр дагавар үүсгэлгүй, комплайнс, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, холбогдох журмын хэрэгжилтийг хангахад чиглэсэн дотоод сургалтын хөтөлбөр боловсруулан ажилласан.

Мөн 2021 онд батлагдсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр”-ийг 2023 онд үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн, шинэчилсэн.

Компанийн Комплайнс хариуцсан ажилтан, удирдлага, эрсдэлийн менежер, хөрөнгө оруулалтын сангийн менежер зэрэг 5 ажилтныг Санхүүгийн зохицуулах хороо болон

Санхүүгийн боловсролын HUB байгууллагаас зохион байгуулсан “Комплайнсын ажилтныг мэргэшүүлэх” Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Үнэт цаасны салбарын мэдээлэх үүрэгтэй этгээдийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны талаарх сертификаттай сургалтад хамруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-4.1.10-д заасан мэдээлэх үүрэгтэй этгээдийн үйл ажиллагаанд энэ хуулиар болон Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг хангуулах чиглэлд Санхүүгийн зохицуулах хорооноос хяналт шалгалтыг эрсдэлд суурилсан хэлбэрээр хэрэгжүүлдэг. Энэ хүрээнд “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлийн үнэлгээний асуулга”-ыг цахим хэлбэрээр хагас болон бүтэн жилээр гарган тайлагнаж ажилласан.

Монгол банкны Санхүүгийн мэдээллийн алба нь мэдээлэх үүрэгтэй этгээдийн мэдээлэл өгөх сувгийг нэмэгдүүлсэн бөгөөд компани www.goaml.mongolbank.mn цахим хаягт бүртгүүлэн, шаардлагатай тохиолдолд холбогдох тайлан, мэдээллийг хүргүүлэн ажилласан байна.

ДОТООД ХЯНАЛТ

Компанийн дотоод хяналт нь Монгол Улсын хууль, тогтоомжийн хүрээнд хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулан, компанийн засаглал, холбогдох хууль, дүрэм, журмын нийцлийг хангуулах, эрсдэлээс сэргийлэхэд чиглэсэн системтэй хяналт, шалгалт хийж, дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Үүнд:

Дотоод хяналт эрсдэлийн хүрээнд 2024 онд 6 зорилтын хүрээнд 31 ажил төлөвлөж ТУЗ-ийн аудитын хороонд танилцуулан хянауулж, ТУЗ-ийн даргаар батлуулан, биелэлтийг бүрэн хангаж ажилласан.

Компанийн эрсдэлийг үнэлэх , илэрсэн эрсдэлийг бууруулах, Сангуудын эрсдэлийг үнэлэх, илэрсэн эрсдэлийг бууруулах, Хөрөнгө оруулалтын эрсдэлийг үнэлэх зорилтуудын хүрээнд 10 ажил төлөвлөж, гүйцэтгэлийг хангаж ажилласан ба эрсдэлийн удирдлага хэсэгт тайлагнасан.

Санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх зорилтын хүрээнд 4 ажил төлөвлөж, Сангуудын 2023 оны 4 дүгээр улирал, 2024 оны 1-4 дүгээр улирлын санхүүгийн тайлан баланс гаргалт, тайлагналт, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, Компанийн санхүү аж ахуйн үйл ажиллагааг хууль, стандарт, бодлогын дагуу бүртгэж тайлагнасан байдал, цалин хөлсний

олголт зэрэгт нийт 5 удаагийн хяналт шалгалт хийж, 19 зөрчил илрүүлж, зөвлөмж хүргүүлж, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажилласан. Үүний үр дүнд зөрчлийг бүрэн барагдуулсан.

2024 оны жилийн санхүүгийн тайлан тэнцлийг алдаа зөрчилгүй гаргахад дотоод хяналтаас байнгын хяналт тавьж ажилласаны үр дүнд компани болон сангуудын санхүүгийн тайлан гаргалтад нийслэлийн төрийн аудитаас хийсэн шалгалтаар зөрчилгүй дүгнэлт гарч, дотоод хяналт эрсдлийн тогтолцоонд эерэг дүгнэлт өгсөн.

Албаны үйл ажиллагааг сайжруулах зорилтын хүрээнд 3 ажил төлөвлөж, гүйцэтгэлийг бүрэн хангаж ажилласан байна.

Компанийн үйл ажиллагааг сайжруулах зорилтын хүрээнд 13 ажил төлөвлөж, гүйцэтгэлийг хангаж ажилласан ба 9 удаагийн хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, шалгалтаар илэрсэн зөрчилд дүгнэлт, санал, зөвлөмж өгч, биелэлтэд хяналт тавьж ажилласаны үр дүнд Компанийн гүйцэтгэлийн төлөвлөгөө 96 хувийн, компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 93,4 хувийн биелэлттэй гарсан.

Чанарын менежментийн тогтолцоонд дотоод аудит хийх зорилтын хүрээнд 2 ажил төлөвлөж, Магадлан-I аудитаар өгсөн сайжруулах ажлын хүрээнд төлөвлөгөө гарган гүйцэтгэх захирлын 2024 оны А/07 тушаалаар батлуулан дотоод аудитын ажлыг зохион байгуулан ажилласан. Үүний үр дүнд магадлан-II аудитад амжилттай оролцон, менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын гэрчилгээг үргэлжлүүлэн хадгалахаар болсон.

3.5. ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Нийслэл, хувийн хэвшил болон мэргэжлийн холбоодтой хамтын ажиллагааг үргэлжлүүлэн шинэ төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, шинээр хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрт хөрөнгө оруулалтын сангаар дамжуулан хөрөнгө оруулалт хийх, санд хөрөнгө татан төвлөрүүлэх боломжийг судлан ажилласан.

Манай компани Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэн, Нийслэлийн Засаг Даргын Тамгын газар болон түүний харьяа байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллаж, Олон Улсын болон дотоодын хөрөнгө оруулалт, санхүүжилтийн боломжуудыг эрэлхийлэн, төслүүдийг хэрэгжүүлэхэд анхаарч ажилласан.

ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГАА

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал нь манай компанийн хувьцаа эзэмшигчдийг томилох, чөлөөлөх асуудлууд болон бусад бодлогын асуудлуудыг шийдвэрлэн, үйл ажиллагааны чиглэлүүдийг баталдаг. 2024 онд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн томилгоо, чөлөөлөлт зэрэг асуудлууд амжилттай хэрэгжиж, компанийн удирдлагын тогтвортой байдал хангагдсан.

Нийслэлийн Засаг Дарга болон НЗДТГазар

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө, Монгол Улсын Засгийн газрын бодлого шийдвэр хүрээнд Нийслэлийн засаг дарга болон НЗДТГ-ын чиглэлийг хэрэгжүүлэн ажиллалаа. Энэ нь нийслэлийн хөгжлийн стратегийн хүрээнд хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлт, шинэ бүтээн байгуулалтын төсөлд манай компани нь мэргэжлийн байгууллагын үүднээс санхүүгийн схемүүдэд оролцох боломжуудыг өргөжүүлсэн.

Санхүүгийн Зохицуулах Хорооны Үйл Ажиллагаа

Санхүүгийн зохицуулах хороо нь хөрөнгийн зах зээлийн харилцаанд оролцогч компаниудын мэргэжлийн үйл ажиллагааг хууль, журмын хүрээнд амжилттай ажиллах, Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн итгэлийг хүлээсэн ухаалаг санхүүгийн зах зээлийг цогцлооход чиглүүлэлт хийдэг. Энэ нь хөрөнгө оруулалт, санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдал, үнэн зөв байдалд чухал нөлөө үзүүлсэн.

Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрдлэгчдийн Холбоо

Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо болон бусад мэргэжлийн оролцогчидтой хамтран сургалт, ур чадварын хөтөлбөрүүдэд ажилтнуудыг хамруулан ажилласан. Энэ хамтын ажиллагаа нь хөрөнгийн зах зээлийг илүү мэргэжлийн, өндөр ур чадвартай оролцогчидтой болгоход хувь нэмэр оруулсан. Мөн үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны гишүүний хувьд зах зээлийн орчныг шинэчлэх, хөрөнгө оруулалт татах, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах ажлуудыг хамтран зохион байгуулсан.

Цэцэнс Майнинг Энэржи (Бөөрөлжүүтийн Цахилгаан Станцын Төсөлд Хөрөнгө Оруулалт)



2024 оны 6-р сарын 25-ны өдөр “Нийслэлийн Хөгжлийн Сан Хувийн ХОС ТЗК” ХХК 300 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг Бөөрөлжүүтийн цахилгаан станцын төсөлд амжилттай хийсэн. Энэ төсөл Монголын дотоод цахилгаан эрчим хүчний хэрэглээний 20%-ийг хангах, жил бүр өсөж буй эрчим хүчний дутагдлыг нөхөх өндөр ач холбогдолтой. Цэцэнс Майнинг Энэржи компанитай холбоотой төсөл болон хамтын ажиллагаа нь эрчим хүчний салбарт хөрөнгө оруулалтын шинэ боломжуудыг судалж, санхүүгийн үр ашигтай байх нь бидний анхаарлын төвд байсаар байна.

Хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчид



Бид бусад андеррайтер, брокер, диллерүүдтэй хамтран ажлын чиглэлүүдийг өргөжүүлж, хөрөнгийн зах зээл дээрх хамгийн сайн боломжуудыг эрэлхийлж, шинэ хөрөнгө оруулалт, санхүүгийн үйлчилгээний шинэ боломжуудыг бий болгож байна.

Кастодион Банкнууд болон Банкууд

Монголын банкуудтай хамтран банкуудад хадгаламж байршуулахаас гадна хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, санхүүгийн зах зээлд тогтвортой байдлыг хадгалахад шаардлагатай үйл ажиллагаануудыг хэрэгжүүлсэн. Бид хамтран банкны санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүрээг өргөжүүлэхээр зорьж байна. Мөн тэдний Кастодион банкуудтай үйл ажиллагааны зайлшгүй хэрэгцээ шаардлагаар хамтран ажиллаж буй ч цаашлаад хөрөнгийн менежмент, санхүүгийн зах зээлийн үйл ажиллагааг сайжруулахад анхаарч ажиллана. Бид энэ хамтын ажиллагаагаар санхүүгийн үйлчилгээ, хөрөнгийн хамгаалалт зэрэг олон чиглэлд хамтран ажиллах төлөвлөгөөг боловсруулсан.

Мэргэжлийн Холбоод, Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим

Манай компани Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын гишүүнээр элсэж, хамтын ажиллагааны хүрээнд бизнесийн харилцаа, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний боломжуудыг хөгжүүлж байна. Жишээлбэл, манай зүгээс МҮХАҮТ-тай хамтран Өглөөний цай, Member care хөтөлбөрийн хэрэгжүүлж байна.

Бизнесийн холбоод



Хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн төрөлжилтийг өндөр болгох зорилгын хүрээнд Money Market буюу мөнгөний захын санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх боломжуудыг судалж, хөрөнгө оруулалтын хувилбаруудаа нэмэгдүүлэхээр зорьж байна. Нийслэлд үйл ажиллагаагаа явуулдаг томоохон 4 старт-ап HUB-тай хамтран ажиллах боломжийг судалж, гарааны бизнесийг дэмжих талаар хамтын ажиллагааг өргөжүүлэхээр

тохиролцов. Түүнчлэн, Монгол дахь 500 гаруй бизнесийн хамтын ажиллагааг хөгжүүлэх санамж бичиг байгуулах санал гаргалаа.

ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

Гадаад хамтын ажиллагааны хувьд манай компанийн Олон Улсын хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалт татах, төсөл хэрэгжүүлэх чиглэлээр хийсэн амжилттай үйл ажиллагааг харуулж байна. "Эрүүл Ой" төсөл, Ази-Хонг Конг, АНУ-ын зарим байгууллагуудтай хийсэн хамтын ажиллагаа нь Монголын эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх томоохон төсөл болон хөрөнгө оруулалтын боломжууд нь манай компанийн стратегийн зорилтуудыг амжилттай хэрэгжүүлэхэд түлхэц болох юм.

Түүнчлэн манай гадаад хамтын ажиллагаа нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтод нийцсэн ногоон хөгжлийг дэмжих, байгаль орчны хамгаалалтад хувь нэмэр оруулахад чиглэгдсэн бөгөөд эдийн засгийн өсөлт, шинэ бизнесийн санаачилга болон хөрөнгө оруулалт татах үйл ажиллагаа маань урт хугацааны дэд бүтцийн хөгжилд хувь нэмэр оруулах боломжийг бүрдүүлж байна.

Ирээдүйн хамтын ажиллагаануудыг өргөжүүлэн, шинэ зах зээлд хөрөнгө оруулалт татаж, дэлхийн шилдэг туршлагыг Монгол Улсын эдийн засаг, байгаль орчны салбарт хэрэгжүүлснээр бид үйл ажиллагааныхаа үр ашгийг нэмэгдүүлж, Нийслэлийн хөгжилд шинэ шат ахихад хувь нэмэр оруулах болно.

Цаашид, дээрх төслүүдийн үр дүнг сайжруулах, хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр илүү их хүчин чармайлт гарган ажиллах бөгөөд Монгол Улсын хөгжилд чиглэсэн төсөл хэрэгжүүлэлтээ үргэлжлүүлнэ.

ХОЛБОО ТОГТООСОН ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУД

"ICCF - Эрүүл Ой" Төсөл



"Эрүүл Ой" төсөл нь АНУ-ын ойн шавжийн мэргэжилтнүүдтэй хамтран ойн шавжийн тэмцэл болон техникийн ажлыг гүйцэтгэж, онгоц болон үүргэн шүршигчийн норм тунг тохируулах, баталгаажуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Төслийн хүрээнд, ойн шавжийн тэмцлийн ажлын бэлдмэл болон техникийн талаарх судалгаа, хөгжүүлэлтүүдийг хийж, ойн


хамгааллын чиглэлээр хамтран ажиллах боломжуудыг судалсан. Энэ төсөл нь экологийн тэнцвэрийг хангах, ойн нөөцийг хамгаалах зорилготой бөгөөд олон улсын мэргэжилтнүүдийн тусламжтайгаар Монголын ойн үйл ажиллагааг сайжруулахад хувь нэмэр оруулж байна.

ADB Хамтран Хэрэгжүүлж буй Төсөл



Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд 18.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг оруулж батлуулсан. Тус төсөл нь Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газраас Улаанбаатар Хөрөнгө оруулалт, Менежмент ҮЦК ХХК-д итгэмжлэл олгох, үлдсэн хөрөнгө оруулалтыг шийдэх, ногоон санхүүжилтийн корпорацийн хуулийн нийцлийг хангуулахад чиглэсэн. Төслийн хүрээнд, Нийслэлийн Ногоон сан Хувийн ХОС ТЗК ХХК-р дамжуулан хэрэгжүүлэхээр судалгаа үргэлжилж байна. Азийн Хөгжлийн Банкнаас өгсөн үнэлгээгээр, манай компани хууль эрх зүйн болон санхүүгийн чадвараараа төслийг амжилттай хэрэгжүүлэх боломжтой гэж үнэлэгдсэн.

Хонг Конгийн Хөрөнгийн Зах Зээл



2024 онд Хонг Конгийн хөрөнгийн зах зээлийн GUOTAI JUNAN International компанийн төлөөлөгчидтэй уулзаж, Монгол улсын зах зээлд хамтран ажиллах боломжуудыг ярилцсан. Энэ уулзалтаар Хонг Конгийн зах зээлд Улаанбаатар хотын бонд гарах боломжийг судалж, цаашид хөрөнгө оруулалт болон санхүүгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар санал солилцсон.

CNBC TV



Манай компани CNBC TV хэвлэл мэдээллийн байгууллагатай уулзалт хийж, хамтын ажиллагааны боломжуудыг судлав. Уулзалтаар CNBC TV-ийн сувгуудаар манай компанийн үйл ажиллагаа, төслүүдийн талаар мэдээлэл түгээх, ярилцлага хийх болон бусад төлбөртэй сувгуудыг ашиглах талаар хэлэлцэв. Энэ хамтын ажиллагаа нь манай компанийн үйл ажиллагааг олон нийтэд таниулах, хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахад чухал ач холбогдолтой юм.

Capital Market Mongolia

Манай компани Capital Market Mongolia компанитай хамтын ажиллагааг эхлүүлэв. Бид, Ulaanbaatar Investment Forum 2025 болон Mongolia Investment Forum in New York арга хэмжээг хамтран зохион байгуулах талаарх саналаа НЗДТГ-ын Гадаад харилцааны хэлтэст хүргүүлсэн болно. Бид дээрх Олон Улсын хөрөнгө оруулалтын арга хэмжээг амжилттай зохион байгуулвал, манай улсын хөрөнгийн зах зээлийг болоод Нийслэлд шаардлагатай байгаа хөрөнгө оруулалты төслүүдийг Олон Улсын хөрөнгө оруулагчдад таниулах, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад чиглэгдэх юм.

Mongol ID компани

Манай компани Mongol ID компанитай гадаад зах зээлд хөрөнгө оруулалт хийх боломжийн талаар болон хамтын ажиллагааны чиглэлүүдийг тодорхойлж, гадаад зах зээлд хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулалтын төслүүдийг хамтран хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Энэхүү хамтын ажиллагаа нь манай компанийн Олон Улсын хөрөнгө оруулалтын боломжийг өргөжүүлэх, гадаад зах зээлд таниулахад туслах болно.

ДӨРӨВ. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

4.1. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Компани зардал хэмнэх бодлого баримтлан, төсөвт зардлыг 31,51 хувиар хэмнэж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төсвийн гүйцэтгэл:

/мянган төгрөгөөр/

№	Зардлын зүйл	2024 оны батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт/+, хэмнэлт -/	Гүйцэтгэл %	Хэтрэлт, хэмнэлт %
1	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	867,321.78	594,071.77	(273,250.02)	68.49	(31.51)
2	Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал	108,415.22	68,187.4	(40,227.82)	62.89	(37.11)
3	Түрээсийн байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	204,000.0	184,048.27	(19,951.73)	90.22	(9.78)
4	Харилцаа холбоо, интернэт	6,000.0	2,751.60	(3,248.4)	45.86	(54.14)
5	Үйл ажиллагааны зардал	131,500.0	86,887.4	(44,612.6)	66.07	(33.93)
6	Хангамж, бараа материалын зардал	55,000.0	50,721.8	(4,278.2)	92.22	(7.78)
7	Үндсэн хөрөнгө, эд хогшил, урсгал засварын зардал	115,899.8	97,730.0	18,169.8	84.32	15,68
8	Томилолт, зочны зардал	84,833.6	13,514.5	(71,319.1)	15.93	(84.07)
9	ТУЗ холбоотой зардлууд	104,100.0	70.193.10	(33,906.90)	67.43	(32.57)
ДҮН		1,788,210.4	1.247,125.65	(541,084.76)	69.74	(30.26)

4.2. САНХҮҮГИЙН ҮР ДҮН

Компанийн орлого 2024 онд өмнөх оноос 43.07 хувиар өссөн нь сангуудын үйл ажиллагаа тогтворжиж, менежментийн үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалтаас олох орлогын хэмжээ өссөн мөн хадгаламжын хүүгийн өсөлттэй холбоотой байна. Мөн компанийн үйл ажиллагаа өргөжиж орон тоогоо чадварлаг мэргэжлийн боловсон бүрдүүлсэн. Нэгтгэсэн тайлангаар 1,500,174.85 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны ашигтай гарснаар өмнөх онуудын хуримтлагдсан алдагдлыг 100% бууруулж, хуримтлагдсан ашиг 762,546.71 мянган төгрөг болсон байна.

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Гүйцэтгэл		Өөрчлөлт	
			2023 он	2024 он	Тоо	Хувь
1	Үнэт цаасны арилжааны цэвэр орлого	мян.төг	468,010.3	23,216,059.0	22,748,048.7	49.6 дахин их
2	Хүүгийн орлого	мян.төг	873,142.4	817,727.8	(55,414.6)	6,3
3	Бусад орлого	мян.төг	1,019.2	800,277.5	799,258.3	785 дахин их
3	Үйл ажиллагааны нийт зардал	мян.төг	808,850.7	1,362,410.1	553,559.4	68,4
4	Үндсэн үйл ажиллагааны ашиг, алдагдал	мян.төг	532,598.1	1,608,640.6	1,076,042.5	3 дахин их
5	Ашгийн хувь	хувь	39.7	6.4	33.3	
6	Санхүүгийн зардал	мян.төг	-	21,863,013.7	21,863,013.7	100.0
7	Орлогын татварын зардал	мян.төг	87,125.1	108,465.8	1,413,049.7	
8	Татварын дараахь ашиг, алдагдал	мян.төг	445,472.3	1,500,174.8	611,086.2	
9	Ажилтны тоо	хүн	12	19	(7)	
10	Цалингийн зардал	мян.төг	320,642.1	594,071.7	(62,363.3)	(16.2)
11	Хөрөнгө оруулалт	мян.төг	2,246,200.0	302,624,335.8	1,659,600.0	3.8 дахин их
12	Нийт өр төлбөр	мян.төг	3,170,507.2	3,313,848.2	42,518.9	1.3
13	Нийт хөрөнгө	мян.төг	11,933,865.6	313,576,394.9	487,991.2	4.2

4.3. 2024 ОНЫ НЭГТГЭСЭН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2024.12.31-ний өдрөөрх үлдэгдэл	Үүнээс:				
		НӨУБХОМК	Нийслэлийн ногоон Сан	Нийслэлийн хөгжлийн сан	Нийслэлийн эрсдлийн удирдлагын сан	Нийслэлийн гарааны бизнесийг дэмжих сан
Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө	9,448,038.1	7,848,987.6	118,004.5	897,672.9	309,495.7	273,877.3
Дансны авлага	1,362,436.5	531,724.3	40.4	1,103,089.0	13,367.1	23,344.5
Татвар, НДШ – ийн авлага	7,005.2	7,005.2				
Бусад санхүүгийн хөрөнгө	2,450,000.0			1,900,000.0	350,000.0	200,000.0
Бараа материал	4,427.6	4,427.6				
Эргэлтийн хөрөнгийн дүн	13,274,478.9	8,394,716.1	118,044.9	9,900,761.9	672,862.9	497,221.8
Үндсэн хөрөнгө	122,189.5	122,946.7				
Биет бус хөрөнгө	5,390.6	5,390.6		41.2		

Үй ажиллагааны тайлан						
Урт хугацаат хөрөнгө оруулалт	300,174,335.8	3,100,000.0		300,000,000.0		174,335.8
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	300,301,916.0	3,144,926.8	-	300,000,041.2	-	174,335.8
Нийт хөрөнгийн дүн	313,576,394.9	11,622,255.1	118,044.9	303,900,803.1	672,862.9	671,557.7
Дансны өглөг	941,843.6	24.0	1,297.2	1,238,745.6	5,475.9	5,429.6
Цалингийн өглөг	833.8	833.8				
Татварын өр	71,170.8	70,842.9	-	327.8	-	
НДШ - ийн өглөг	-	-				
Урьдчилж орсон орлого	2,300,000.0	2,300,000.0				
Богино хугацаат өр төлбөрийн дүн	3,313,848.2	2,371,700.8	1,297.2	1,239,073.4	5,475.9	5,429.6
Өр төлбөрийн нийт дүн	3,313,848.2	2,371,700.8	1,297.2	1,239,073.4	5,475.9	5,429.6
-төрийн	309,500,000.0	9,500,000.0	100,000.0	302,000,000.0	500,000.0	500,000.0
Хуримтлагдсан ашиг	(737,628.1)	(1,223,439.7)	9,445.9	331,472.1	89,331.2	56,548.8
Тайлант үеийн үр дүн	1,500,174.8	976,192.1	7,187.8	329,159.8	78,055.7	109,579.3
Эздийн өмчийн дүн	310,262,546.7	9,250,554.3	116,633.8	302,660,632.0	667,386.9	666,128.1
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	313,576,394.9	11,622,255.1	118,044.9	303,900,803.1	672,862.9	671,557.7

Компанийн тайлант хугацаанд Нийслэлийн хөгжлийн сан, Нийслэлийн Гарааны Бизнесийг Дэмжих сан болон Нийслэлийн эрсдлийн удирдлагын сангаас нийт 302,624,335.8 мянган төгрөгөөр урт болон богино хугацаат санхүүгийн хэрэгслүүдэд хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд хөрөнгө оруулалтын сангууд 23,216,059.0 мянган төгрөгийн үнэт цаасны арилжааны орлого олсон байна.

4.4. ХӨНДЛӨНГИЙН АУДИТЫН ДҮГНЭЛТ

Нийслэл дэх Төрийн аудитын газрын шийдвэрээр сонгогдсон Си Эс Ай Аудит ХХК нь гэрээний дагуу компанийн 2024 оны санхүүгийн тайланд аудит хийж ажилласан.

2024 оны аудитын дүгнэлт: